

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2025 – 12 САР | ДУГААР 85

ГАРЧИГ

1–3 Бодлогын нийтлэл

4–6 Зохицуулалтын мэдээ

7–8 Ярилцлага

9–10 Тогтвортой санхүүжилт

11–12 Компанийн засаглал, комплайнс

13–14 Финтек ба регтек

15–23 Судлаачийн индэр

24–25 Цахимаар үнэт эдлэл худалдан авах ямар эрсдэлтэй вэ?

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (IRENA) болон Уур амьсгалын бодлогын санаачилга (Climate Policy Initiative, CPI) хамтран боловсруулсан “Эрчим хүчний шилжилтийн санхүүжилтийн байдал 2025” судалгааны тайланг хүргэж байна.

Дэлхийн эрчим хүчний салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 2024 онд 2.4 их наяд ам.долларт хүрч, 2022–2023 оны дундаж жилийн түвшинтэй харьцуулахад 20 хувиар өссөн нь түүхэн дээд үзүүлэлт боллоо.

Хөгжлийн харьцангуй өндөр түвшинд хүрсэн технологиуд болох сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, цахилгаан дамжуулах сүлжээ болон цахилгаан тээврийн хэрэгслийн салбарууд дахь хөрөнгө оруулалт 2024 онд өсөлтөө хадгалсан боловч өмнөх жилүүдтэй харьцуулахад өсөлтийн хурд саарсан байна. Харин шинээр хөгжиж буй технологиуд болох ногоон устөрөгч болон нүүрстөрөгчийн үйлдвэрлэлийн байгууламж барих, хадгалах технологи (CCS)–д чиглэсэн хөрөнгө оруулалт 2024 онд буурчээ. Харин батарей хуримтлуурын салбар нь онцгой өсөлттэй байсан бөгөөд 2024 оны туршид тогтвортой бөгөөд өндөр өсөлтийг хадгалсан хэвээр байна. 2019 оноос хойш сэргээгдэх эрчим хүчний салбарт ногдох хөрөнгө оруулалтын эзлэх хувь харьцангуй тогтвортой байж, нийт хөрөнгө оруулалтын ойролцоогоор гуравны нэгийг эзэлж байна (2024 онд 35 хувь). Харин эрчим хүчний шилжилтийн бусад технологиудад чиглэсэн хөрөнгө оруулалтын бүтэц нэлээд өөрчлөгдсөн байна.

Цахилгаан тээврийн хэрэгсэл болон цэнэглэх дэд бүтцэд чиглэсэн хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2019–2024 оны хооронд 13.6 хувиас 31.6 хувь хүртэл нэмэгдсэн бол цахилгаан эрчим хүчний сүлжээ болон эрчим хүчний үр ашгийн салбаруудад ногдох хөрөнгө оруулалтын хувь хэмжээ тус тус 26 болон 20 хувиас буурч, нийлбэр дүнгээрээ 29 хувь болж, хоёр салбарын хооронд бараг тэнцүү хуваарилагдсан байна.



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Зохицуулалтын сэндрокс

Regulatory sandbox

Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших зохицуулалтын орчин.



Зохицуулалтын технологи

Regtech

Зохицуулалтын технологи буюу RegTech нь байгууллагууд зохицуулалтын нийцлээ хангах, сайжруулахын тулд дижитал арга хэрэгсэл, шинээр гарч ирж буй технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглах явдал юм.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь 2024 он

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)–ИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Монгол Улсад хадгаламж, зээлийн хоршоод 1996 оноос эхлэн байгуулагдаж, 30 орчим жилийн хугацаанд түүхийн үе шатуудыг дамжин санхүүгийн зах зээлд тодорхой байр суурийг эзэлсээр өнөөдрийг хүрсэн. Анх хадгаламж, зээлийн хоршоод Монголбанкны зохицуулалтад байсан бөгөөд төв банкнаас хяналт тавьж байсан ба Санхүүгийн зохицуулах хороо 2006 онд байгуулагдсанаар хадгаламж, зээлийн хоршоодод тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх, үүрэг шилжсэн.

Улсын Их Хурлаас 2011 онд 10 бүлэг, 57 зүйл бүхий Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталснаар хадгаламж, зээлийн хоршооны салбар бие даасан хуультай болсон. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотой, 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой, 2023 онд Зөвшөөрлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)–тай холбоотой, 2024 онд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос өөрөөр шинэчлэлт хийгдээгүй.

Хуулийн хэрэгжилтэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, салбарын хөгжил дэвшлийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, гишүүдийн нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бүрэн хангахуйц, хөдөө аж ахуйн орны онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээтэй хадгаламж, зээлийн хоршоог хөгжүүлэх эрх зүйн орчин, зохицуулалтыг бий болгох шаардлага үүссэн. Өнгөрсөн хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос салбарын оролцогчдын дунд явуулсан судалгаа, зохицуулалттай этгээдүүдээс ирүүлсэн санал, хүсэлт, олон улсын чиг хандлагад тулгуурлан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хадгаламж, зээлийн хоршооны нэршлийг санхүүгийн хоршоо болгон өөрчлөх шаардлага гарсан. Учир нь 2006 оны үеийн хадгаламж, зээлийн хоршооны салбарын хямралаар иргэдийн дунд хадгаламж, зээлийн хоршооны талаар сөрөг ойлголт газар авсан бөгөөд одоог хүртэл хэвээр байна. Нөгөөтэйгүүр, хадгаламж, зээлээс гадна санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэх санаагаар “санхүүгийн хоршоо” гэсэн өргөн хүрээний нэр томъёогоор өөрчлөхийг зорьсон.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийг дараах байдлаар харж байна. Үүнд:

1. Хадгаламж, зээлийн хоршооны салбар дахь 1 давхар хамгаалалтын тогтолцоо 3 давхар бүхий хамгаалалтын тогтолцоонд шилжиж, нэгдсэн дэд бүтэцтэй болно. Тодруулбал:
 - а. Дэлхийн улс орнууд хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд хадгаламж, зээлийн хоршооны салбарт хамгаалалтын 2–3 давхарга бүхий

тогтолцоог үйл ажиллагаандаа ашиглаж ирсэн. Манай улсын хадгаламж, зээлийн хоршоодын хувьд хамгаалалтын нэгдүгээр давхарга буюу нөөцийн санг цэвэр орлогоос бүрдүүлж эрсдэлээс хамгаалж байна.

- б. Хамгаалалтын хоёрдугаар давхарга буюу санхүүгийн хүндрэлд орсон хадгаламж, зээлийн хоршоодод туслалцаа үзүүлж, үйл ажиллагааг сэргээхэд чиглэдэг тогтворжуулалтын сангийн зохицуулалтын талаар одоо мөрдөгдөж буй хуульд туссан боловч хэрэгжээгүй. Учир нь тогтворжуулалтын санг удирдах байгууллага нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий дээвэр байгууллага байдаг бол хуульд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо буюу төрийн бус байгууллага тус үйлчилгээг үзүүлэхээр тусгасан тул тогтворжуулалтын сангийн буюу санхүүгийн төвлөрсөн үйл ажиллагааг эрхлэх боломжгүй болсон.
- в. Хамгаалалтын гуравдугаар давхарга болох хадгаламж, зээлийн хоршоо дампуурсан тохиолдолд даатгагдсан хадгаламжийг хадгаламж эзэмшигчдэд нөхөн олгодог хадгаламж хамгааллын тогтолцооны талаар мөн одоогийн мөрдөгдөж байгаа хуульд туссан хэдий ч Монгол Улсын хадгаламжийн даатгалын систем зөвхөн банкин дахь мөнгөн хадгаламжид хамаарч, хадгаламж, зээлийн хоршооны хадгаламж эзэмшигч гишүүдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах зохицуулалтыг орхигдуулсан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан олон давхаргат хамгаалалтын тогтолцоог үе шаттай нэвтрүүлснээр салбарыг тогтвортой хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах хэрэгцээ шаардлага хангагдах юм.

2. Тогтворжуулалтын санг удирдах санхүүгийн хоршоодын дундын санхүүгийн төвлөрсөн дээвэр байгууллага болох Санхүүгийн хоршоодын нэгдсэн төвийг бий болгох талаар хуулийн төсөлд тусгасан. Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв нь тусгай зөвшөөрөлтэй санхүүгийн хоршоодын заавал гишүүнчлэлтэй байх бөгөөд гишүүддээ санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр салбар нэгдсэн бүтэц, зохион байгуулалтад орж, салбарын эрсдэл буурч, хөгжлийн шинэ шатанд гарснаар санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй иргэдийн санхүүгийн хүртээмж болон ажлын байр нэмэгдэж, ядуурал буурна.
3. Санхүүгийн хоршоогоор дамжуулан иргэдэд санхүүгийн боловсрол олгож, зөв дадал хэвшил суулгаснаар төв

газраас алслагдсан орон нутгийн иргэдийн амьдралын чанар дээшилж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа багасна. Санхүүгийн хоршоо санхүүгийн үйлчилгээ авах шаардлагатай, боломжтой бүхий л хүнд хүрч үйлчлэхийг зорьдог гишүүддээ ойр байгууллага болохоос гадна гишүүд эзэд нь байдаг учир хоршооноос үүссэн “ашиг” тухайн орон нутагт, гишүүддээ үлдсэнээр орон нутгийг хөгжүүлнэ.

4. Санхүүгийн хоршооны засаглал, санхүүгийн тайлагнал, технологийн дэвшил, цахим шилжилттэй холбоотой өөрчлөлтүүдээс гадна ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтууд хийгдсэнээр санхүүгийн хоршооны зах зээлийн тогтвортой байдал хангагдаж, гишүүдийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болох ач холбогдолтой болсон.
5. Гишүүн элсэх, гишүүнээс гарах, идэвхгүй гишүүнд тооцох, гишүүнийг хасах харилцааг одоогийн мөрдөгдөж буй хуульд нарийвчилж зохицуулаагүй тул хоршооны үйл ажиллагаанд оролцоогүй, хуримтлал үүсгэх үүргээ биелүүлээгүй зэргийг харгалзаж гишүүнийг хэрхэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр гишүүдийн хариуцлага, идэвх оролцоо нэмэгдэж, нийгмийн харилцаа сайжирна.
6. Гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор үзүүлж болох үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлнэ. Даатгалын зуучлагч, санхүүгийн түрээс, факторингийн зэрэг үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгоно. Мөн үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангасан хоршоонд Монголбанкнаас олгох зөвшөөрлийн үндсэн дээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх зэрэг зохицуулалтыг тусгаж өгсөн. Ингэснээр санхүүгийн хоршооны гишүүн бүх хэрэгцээт санхүүгийн үйлчилгээгээ өөрийн хувь эзэмшил бүхий санхүүгийн байгууллагаасаа авснаар ашиг нь мөн л өөрсдөд нь, тухайн бүс нутагт нь үлдэж эдийн засгийн үр өгөөжөө өгнө.
7. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд тавьж буй хяналт шалгалтын үр нөлөө дээшилж, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох боломж нэмэгдэж, эрсдэл буурч зохицуулалтын эрх зүйн орчин олон улсын жишигт нийцнэ. Мөн түүнчлэн санхүүгийн хоршооны үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, гишүүн төвтэй зохицуулалтын орчин бүрдсэнээр тус салбар ихэнх улсад нийгэмдээ үнэ цэнтэй үүргээ гүйцэтгэж байгаа жишиг загварт нийцэж хөгжлийн шинэ шатандаа гарах юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫХАА ҮР ДҮНГ ДҮГНЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны хамт олон 2025 оны үйл ажиллагааны тайлангийн хурлаа зохион байгуулж, жилийн ажлын үр дүнгээ дүгнэн хэлэлцлээ. Тайлангийн хурлыг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамцхэлсэн үгэндээ, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ажилласнаа онцоллоо. Тухайлбал, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хувьцааны хамтын санхүүжилтийн үйлчилгээ, банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжих, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ, олон улсын санхүүгийн байгууллагуудын оролцоотой үнэт цаас гаргах, мөн “нийгмийн бонд”, “тогтвортой байдлын бонд” зэрэг тогтвортой санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр байгуулах зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх зохицуулалтын орчныг бүрдүүлсэн нь чухал үр дүн болсныг тэмдэглэв.

2025 оны байдлаар биржийн болон биржийн бус зах зээлээс бонд гаргах замаар компаниуд нийт 2.86 их наяд төгрөгийн санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлж, хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ түүхэн дээд хэмжээнд хүрч, 13.8 их наяд төгрөгт (2025.12.26-ны байдлаар) хүрсэн нь дотоодын санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байгааг харуулж байна.

Даатгалын салбарт ч олон тулгуурт тогтолцоог хөгжүүлэх,

амьдралын даатгалыг дэмжих, ногоон даатгал, даатгагчийн баталгаа, дэвшилтэт цахим технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааг илтөд, нээлттэй, хариуцлагатай болгох чиглэлээр бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Мөн даатгуулагч, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлд тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлжээ. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Даатгалын багц хууль, Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байгаа нь салбарын тогтвортой хөгжлийг хангах чухал алхам болж байгааг онцоллоо. Түүнчлэн ирж буй 2026 онд зохицуулалтын салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тогтвортой, ногоон санхүүжилт болон санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах бие даасан хяналт шалгалтын тогтолцоог хөгжүүлэхэд анхаарч ажиллана гэдгийг онцолсон юм.

СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛ ЭЭЛЖИТ ХУРАЛДААНАА ХИЙЛЭЭ



Сэндбоксын зөвлөлийн ээлжит хуралдаан болж, сэндбоксын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ турших, туршилтын хугацааг сунгах, сэндбокс зохицуулалтаас шилжих болон гарахтай холбоотой нийт зургаан асуудлыг хэлэлцлээ.

Хуралдааны шийдвэрээр “Дижитал Кредит” ХХК-ийн нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зуучлалын

үйлчилгээг сэндроксын орчинд нэг жилийн хугацаанд туршихыг зөвшөөрөв. Мөн “Фанд Ми Бирж” ХХК, “Зээл Эм Эн Платформ ББСБ” ХХК-ийн сэндроксын орчноос шилжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргалаа.

Түүнчлэн “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ын биржийн бус зах зээл дэх блокчэйн арилжааны систем сэндроксын хугацаанд амжилттай туршигдаж, сэндроксын орчноос гарлаа. Уг туршилтын үр дүнд биржийн бус зах зээлийн арилжааны платформ блокчэйн технологид бүрэн шилжиж, ажлын өдрүүдэд / Даваа-Баасан/ хоногийн 24 цаг тасралтгүй арилжаа хийх боломж бүрдсэн. Үүний зэрэгцээ арилжааны төлбөр тооцооны дундаж хугацаа 45 секунд болж буурч, хоёрдогч зах зээлийн идэвх 6.4 дахин нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсан.

Мөн “Фандиа” ХХК-ийн хамтын санхүүжилтийн үйлчилгээний платформ сэндроксын орчинд амжилттай туршигдаж, зохицуулалтын орчноос гарлаа. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам” батлагдсанаар уг үйл ажиллагааны зохицуулалтын орчин бүрдсэн.

Сэндрокс зохицуулалтын орчин нь технологид суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал нөхцөлд туршиж, амжилттай туршигдсан тохиолдолд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогт нийцсэн зохицуулалтыг бий болгох зорилготой. Энэхүү зохицуулалтыг Монгол Улсад 2021 оноос хэрэгжүүлж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Бичил санхүүгийн бодлогын зөвлөл шинэчлэгдсэн бүрэлдэхүүнээр анхны хуралдаанаа хийлээ. Хуралдаанаар бичил санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнүүдийн талаар хэлэлцлээ. Мөн ирэх оны ажлын төлөвлөгөөгөө ярилцаж, цаашид бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг илүү идэвхтэйгээр өрнүүлж, бодлогын шийдвэр

гаргах түвшинд нөлөөлж ажиллахаар тогтлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн Ө.Гэрэлт-Одоор ахлуулсан тус зөвлөл банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын төлөөлөл, их сургуулийн эрдэмтэн судлаач багш нар, хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөл зэрэг нийт 13 гишүүнтэй ажиллаж байна.

НАМИБИА УЛСЫН ТӨВ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛ УЛСЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БОДЛОГ, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ТАНИЛЦЛАА



Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Намибия Улсын Төвбанкны төлөөлөгчид Монгол Улсын тогтвортой санхүүгийн стратегийн хөгжил, хэрэгжилт, хүртээмжтэй болон ногоон санхүүжилтийн бодлого, зохицуулалтын туршлагатай танилцах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороонд ажиллав.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан бөгөөд ногоон санхүүгийн захзээлийг хөгжүүлэх, бодлогын орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтыг тэлэх чиглэлд хэрэгжүүлж буй онцлох бодлого, арга хэмжээнүүдээс танилцууллаа. Мөн тогтвортой болон уур амьсгалын сэдэвчилсэн өрийн хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлэх, ил тод байдал, тайлагналын тогтолцоог сайжруулах, ногоон төслүүдийг үнэлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй ажлуудаас танилцуулсан юм. Үүний дараа төлөөлөгчид Монгол Улсын үндэсний тогтвортой санхүүгийн экосистем дэх үүрэг, оролцоо, хүртээмжтэй ногоон санхүүжилтийн чиг хандлага, ногоон бондын хөгжил, санхүүгийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, сэндрокс зохицуулалтын туршлагатай танилцаж, санал солилцов. Мөн арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай

газар дээр нь танилцаж, тогтвортой санхүүжилтийг дэмжих бодлого, зохицуулалтын хэрэгжилтийн талаар туршлага солилцохын зэрэгцээ Монголын тогтвортой санхүүгийн холбооноос тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлээр хийж буй ажлын талаар мэдээлэл авлаа.

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР ТОЛЬ “GRAND BULL AWARDS 2025” ШАГНАЛ ХҮРТЛЭЭ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос 4 дэх удаагаа зохион байгуулсан “Grand Bull Awards 2025”-ийн “Хүртээмжтэй боловсрол” номинацид “Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь” бүтээл шалгарч, шагнал хүртлээ.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль хамтран “Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь бичиг”-ийг шинэчлэн боловсруулж, цахим болон хэвлэмэл хэлбэрээр олон нийтэд хүргэсэн. Тайлбар толийг эдийн засаг, санхүүгийн зах зээлд хэрэглэгддэг нэр томьёог нэг мөр ойлгож, хэрэглэх боломжийг бүрдүүлэх, салбарын зохицуулалт, судалгаа, сургалтын үйл ажиллагаанд ойлголтын зөрүүг багасгах, иргэдийн эдийн засаг, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын түвшний нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор боловсруулсан.

Шинэчлэгдсэн толь бичигт нийт 11 бүлэг, 3650 гаруй нэр томьёо орсон бөгөөд гурван байгууллагын 37 эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн хамтран ажилласан.

Өнөөдрийн байдлаар тайлбар толь бичгийн цахим хувилбарт нийт 26,300 удаагийн хандалт хийгдсэн байна. Харин тайлбар толийн хэвлэмэл хувилбарыг нийслэлийн нийт 5 нийтийн номын сан, 21 их дээд, сургуулийн номын сан мөн 17 аймгийн номын сангуудад тус тус байршуулж, Монгол Улсын иргэн бүр ашиглах боломжийг бүрдүүлээд байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ХЭРЭГЖИЛТ, КОМПЛАЙНСЫН СТАНДАРТЫГ ХЭЛЭЛЦЭВ

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компаниудын эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Компанийн засаглал, комплайнс” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, “Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301”, “Нийгмийн хариуцлагын ISO 26000” стандартуудын үндсэн шаардлага, тэдгээрийг практикт нэвтрүүлэх асуудал, даатгалын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй сорилт, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл өгч, оролцогчидтой санал солилцов.

Комплайнсын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх нь компанийн урт хугацааны тогтвортой хөгжил, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл юм. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хэвшүүлэх, мөн Улсын Их Хурлаас баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бодлого, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна.



ЯРИЛЦЛАГА

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ, СОРИЛТ БА БОЛОМЖ

СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн

Сүүлийн жилүүдэд тогтвортой санхүүжилт дэлхий нийтийн анхаарлын төвд орж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн салшгүй нэг хэсэг болж байна. Монгол Улс ч энэ чиглэлээр бодлогын түвшинд шинэчлэл хийж, санхүүгийн салбарын ногоон шилжилтийг дэмжих алхмуудыг эхлүүлээд байна. Энэ удаа бид Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй тогтвортой санхүүжилтийн өнөөгийн байдал, сорилт, боломжийн талаар ярилцлаа.

Тогтвортой санхүүжилт Монголын санхүүгийн зах зээлд ямар ач холбогдолтой гэж та харж байна вэ? Санхүүгийн зохицуулах хороо энэ чиглэлд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?

Тогтвортой Хөгжлийн Зорилгууд нь ядуурлыг бууруулах, байгаль, эх дэлхийгээ хамгаалах, хүн төрөлхтөн амар амгалан, хөгжил цэцэглэлтийн үр шимийг хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааны дэлхийн хэмжээний зорилт бөгөөд нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрийг хангах цогц шинжийг агуулдаг билээ.

Монгол Улсын хувьд 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 30.3 хувиар буюу 24.4 сая тонн CO₂-тэй дүйцэхүйц хэмжээгээр бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, амьдралын чанар болон хүний хөгжлийг дээшлүүлэх, чанартай боловсрол, сайн засаглал бий болгох зэрэг зорилттойгоор Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилт тавьсан байдаг.

Сүүлийн жилүүдэд олон улсын хөрөнгийн зах зээлд тогтвортой болон нийгмийн хариуцлагатай санхүүжилт эрчимтэй хөгжиж, хөрөнгө оруулагчид санхүүгийн өгөөжөөс гадна байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг онцлон үнэлэх болсон. Олон улсын чиг хандлага болон хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцүүлэн зөвхөн эдийн засгийн өсөлтөд бус, ногоон болон тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо 2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д ногоон бондын зохицуулалтын орчныг бий болгож, дотоодын аж ахуйн нэгжүүд байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийг дотоодын хөрөнгийн зах зээлээс татах таатай нөхцөлийг бүрдүүлсэн.

Энэхүү амжилттай туршлагыг уламжлан, олон улсын зах зээлийн чиг хандлагад нийцүүлж, зөвхөн ногоон бондоор

хязгаарлахгүйгээр цар хүрээг өргөжүүлэн нийгмийн бонд болон тогтвортой байдлын бондын зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд дээрх журамд нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Ингэснээр дотоодын зах зээлд тогтвортой санхүүгийн экосистемийг хөгжүүлэх, байгаль орчин болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх шинэ боломжийг бий болгоод байна. Тухайлбал, нийгмийн бондын хүрээнд жендэрийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн оролцоог эдийн засгийн салбарт бодитоор нэмэгдүүлэх, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилготой төсөл, хөтөлбөрүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломж бүрдэж буй юм.

Мөн эдгээр бонд нь хариуцлагатай, нийгмийн болон тогтвортой байдлын үр нөлөө бүхий хөрөнгө оруулалтын соёлыг зах зээлд төлөвшүүлэх, хөрөнгө оруулагчдын хандлагыг өөрчлөх, олон нийтэд нийгмийн хөгжил, тогтвортой байдлын асуудлыг хөрөнгө оруулалтын шийдлээр дэмжих шинэ боломжийг нээж буйгаараа ач холбогдолтой. Цаашлаад энэ нь “Алсын хараа-2050”, “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”, “Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (2020-2025)”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, мөн “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг дэмжих чухал хөшүүрэг болох юм.

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх хамгийн чухал хүчин зүйл бол тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр байдаг. Тэгвэл дотоодын хөрөнгийн зах зээлд тогтвортой санхүүжилтийн хэрэгжилт ямар байгаа вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэхийн тулд компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал, байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид “БОНЗ” гэх)-ын болон Тогтвортой байдлын тогтмол тайлагналын соёлыг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарч байна.

Ногоон, нийгмийн тогтвортой байдлын бондын зохицуулалтын орчин бий болсноор өнөөдрийн байдлаар тус төрлийн нийт 56.2 сая ам.долларын үнийн дүн бүхий 3 үнэт цаас гаргагчийн бонд

дотоодын зах зээлд, 340 сая ам.долларын үнийн дүн бүхий 4 үнэт цаас гаргагчийн бонд олон улсын зах зээлд амжилттай гараад байна.

Өмнө дурдсанчлан нийгмийн бонд болон тогтвортой байдлын бондын зохицуулалтын орчныг бий болгосны үр дүнд энэ оны 7 дугаар сард “ХААН Банк” ХК-аас 30.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий анхны нийгмийн бондын нэг төрөл болох жендэр бондыг гаргасан. Энэхүү бондоос босгосон хөрөнгө нь жендэрийн тэгш байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлт болон эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлт болон баталгаат ажлын байр бий болгоход зарцуулагдаж буйгаараа ихээхэн онцлог бүтээгдэхүүн болсон.

Мөн эдгээр бонд нь зөвхөн дотоодын хөрөнгө оруулагчдыг татахад төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монголын зах зээлд хандуулах чухал хөшүүрэг болж байна. Учир нь дэлхий нийтээр нийгмийн хариуцлага, тогтвортой байдалд чиглэсэн хөрөнгө оруулалтын эрэлт эрчимтэй өсөж, олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангууд “ESG” буюу БОНЗ-ын үзүүлэлтэд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүнд илүүтэй хөрөнгө оруулж буй өнөө үед Монголын зах зээлд ийм төрлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хороо, Олон Улсын Санхүүгийн Корпораци хамтын ажиллагаагаа өргөжүүлж “Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн II үе шат дээр хамтран ажиллахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Харилцан ойлголцлын Санамж бичгийг зурсан. Тус Санамж бичгийн хүрээнд дотоодын зах зээлд олон улсад түгээмэл ашиглагддаг хөх бонд, тогтвортой байдалтай холбоотой бонд зэрэг шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, мөн тогтвортой санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тайлагналыг нэвтрүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн тайлагналын (IFRS) S1, S2 стандартуудыг нэвтрүүлэх хүрээнд хамтарч ажиллахаар тохиролцож, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр болон БОНЗ тайлагналын хэрэгжилт ямар түвшинд байна вэ? Энэ хүрээнд тулгарч буй асуудлууд болон цаашид хэрэгжүүлэх дараагийн бодлогын алхмууд юу байх вэ?

Манай улсын хувьд тогтвортой санхүүжилтийн асуудалд 2013 оноос хойш анхаарал хандуулж, Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр буюу бидний мэддэгээр ТоС хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэн, тасралтгүй хөгжүүлж, өнөөдөр бусад улс орнуудад жишиг, сайн туршлага болох түвшинд хүрсэн байна.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо нь холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран 2022 онд “Байгаль орчин, нийгэм, засаглал, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг боловсруулж, баталснаар нээлттэй хувьцаат компаниуд, үнэт цаас гаргагч, аж ахуйн нэгжүүд болон бусад аль ч хэлбэрийн бизнесийн байгууллагууд сайн дурын үндсэн дээр тайлагнадаг болсон.

Өнөөдрийн байдлаар дэлхий даяар нийт 29 улс БОНЗ-ын тайлагналыг заавал тайлагнах хэмжээнд зохицуулсан байдаг. Харин Монгол Улсын хувьд биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд сайн дурын үндсэн дээр БОНЗ-ын тайланг гаргах зохицуулалтыг бий болгосны хүрээнд анх 4-5 компани тайлагнадаг байсан бол энэ оны хувьд нийт 30 хувьцаат компани “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тайлангаа илгээсэн байна. Одоогийн зохицуулалтын хүрээнд биржийн нэгдүгээр ангилалд хамаарах компаниуд тус тайланг заавал тайлагнах үүрэг хүлээсэн бол бусад ангиллын компаниуд сайн дурын үндсэн дээр тайлагнахаар байна. Бидний зүгээс цаашид заавал тайлагнах компанийн ангиллыг үе шаттайгаар тэлэх бодлогыг баримтлан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Тус БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг компаниуд дагаж мөрдөж хэвшихэд нэг талаас цаг хугацаа нэлээдгүй шаардагдах, нөгөөтэйгүүр аж ахуйн нэгж байгууллагуудад БОНЗ-ын үзүүлэлт, ил тод байдлын ач холбогдлыг сайтар ойлгуулж таниулах чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг авч ажиллах, энэ чиглэлийн боловсон хүчнийг бэлтгэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Үүнтэй холбогду олон нийт, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч компаниудад БОНЗ, тогтвортой байдлын тайлагнал, ногоон санхүүжилтийн талаарх ойлголт, мэдлэгийг өгөх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран сургалт хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулан ажиллах, үүнд ТоС платформыг ашиглаж, нэгдсэн системтэйгээр мэдээллүүдийг хүргэх нь ач холбогдолтой байх болов уу гэж харж байна.

Цаашид БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, тайлагнах компаниудын тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөөд байгаагаас гадна дотоодын компаниуд ч энэ чиглэлд илүү ач холбогдол өгч ажилладаг болно гэдэгт итгэлтэй байна.


Мөн ногоон хөрөнгө оруулалтын төрлийн шинэ бүтээгдэхүүн нэмэгдсэнээр дотоодын хөрөнгийн зах зээл тэлэх, ногоон санхүүгийн урсгал нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нөгөөтэйгүүр Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эхлэл нь 1-р нүүрт

Зураг. Эрчим хүчний шилжилтийн технологи тус бүрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын бүтэц, өөрчлөлт /2019–2024/



Зургаас харахад сүүлийн 6 жилд эрчим хүчний шилжилтийн технологиудад оруулсан хөрөнгө оруулалт бараг 2 дахин өссөн байна. Үүний дотор сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулалт бусдаасаа илүү хөрөнгө оруулалтыг татжээ.

Эрчим хүчний салбарын шилжилтийн технологи тус бүр өөрийн гэсэн онцлог хөшүүрэг, хязгаарлалт тулгардаг тул эдгээр технологиудад чиглэсэн хөрөнгө оруулалт сүүлийн хэдэн жилийн турш харилцан адилгүйгээр хөгжиж ирсэн бөгөөд дараах хоёр нийтлэг хүчин зүйл ажиглагдаж байна. Үүнд:


1. Хөрөнгө оруулалт газарзүйн хуваарилалтын хувьд тэнцвэргүй байна.

Хятад Улс болон өндөр хөгжилтэй эдийн засагтай улс орнууд инновац, технологийн нэвтрүүлэлтийн гол төвүүд болж, 2024 онд эрчим хүчний шилжилтийн нийт хөрөнгө оруулалтын 90 хувийг дангаараа бүрдүүлсэн. Харин буурай хөгжилтэй орнууд (LDCs) нь 2024 онд ойролцоогоор эрчим хүчний шилжилтийн нийт хөрөнгө оруулалтын 0.22 хувиас бага, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын 2.2 хувийг эзэлжээ. Эдгээр улс орны дийлэнх нь Өмнөд сахар болон Африкийн бүс нутагт хамаарах бөгөөд эрчим хүчний асар их нөөцтэй, өсөн нэмэгдэж буй хэрэгцээтэй хэдий ч тус бүс нутаг хөрөнгө оруулалт дутмаг хэвээр байна.

2. Эрчим хүчний шилжилтийн голлох технологиудад хөрөнгө оруулалт IRENA-ийн 1.5°C зорилтот замналд нийцэхэд шаардлагатай түвшинд хүрээгүй хэвээр байна.

Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлагийн “World Energy Transitions Outlook 2024” болон “Delivering the UAE Consensus” тайлангуудад дурдсанаар, 2025–2030 оны хооронд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд чиглэсэн хөрөнгө оруулалт одоогийн түвшнээс бараг хоёр дахин нэмэгдэж, жилд 1.4 их наяд ам.долларт хүрэх төлөвтэй байна (IRENA et al., 2025). Мөн эрчим хүч үйлдвэрлэлээс гадна дулаан халаалт, тээвэр зэрэг эцсийн хэрэглээний салбаруудад сэргээгдэх эрчим хүчний хэрэглээтэй холбоотой хөрөнгө оруулалтыг асар ихээр нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хамгийн их өсөлт шаардлагатай салбар нь эрчим хүчний хэмнэлт бүхий үйлдвэрлэл бөгөөд уг салбарын хөрөнгө оруулалт 2025–2030 онд жилд бараг 2.6 их наяд ам.долларт хүрэхийн тулд одоогийн түвшнээс 7.5 дахин өсөх шаардлагатай (IRENA et al., 2025).

Зураг. Гол эрчим хүчний шилжилтийн технологиуд дахь хөрөнгө оруулалтын дутагдлын байдал



- Тайланд дурдсанаар, сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний салбар дахь хөрөнгө оруулалт өссөн хэдий ч санхүүжилтийн бүтэц нь зах зээлийн нөхцөлтэй зээл болон хувьцааны хөрөнгө давамгайлсан хэвээр байгаа бөгөөд төрийн болон олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зэрэг үр нөлөөнд суурилсан санхүүжилтийн эзлэх хувь харьцангуй бага байна.
- Энэ нь хөрөнгө оруулалтын гол хөдөлгөгч хүчин зүйл нь ашиг, өгөөжид суурилсан шийдвэр хэвээр байгааг харуулж байгаа бөгөөд ялангуяа өндөр эрсдэлтэй, санхүүгийн зах зээл сул хөгжсөн улс орнуудын хувьд сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөрөнгө татахад хүндрэл үүсгэж байгааг онцолжээ.
- Түүнчлэн төрийн болон хувийн санхүүжилтийн зааг улам бүр бүдгэрч байгааг тэмдэглэсэн бөгөөд төрийн эх үүсвэрүүд эрсдэлээс зайлсхийх, зах зээлийн өгөөж хүлээх хандлагатай болж байгаа бол, нөгөө талаас зарим хувийн хөрөнгө оруулагчид компанийн нийгмийн хариуцлага, буцалтгүй тусламж болон тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд санхүүгийн өгөөжөөс илүүтэй нийгэм, байгаль орчны үр нөлөөг чухалчлах болсон байна. Гэсэн хэдий ч ийм төрлийн үр нөлөөнд суурилсан санхүүжилт нь нийт хөрөнгө оруулалтын дүнд хангалттай хэмжээнд хүрээгүй хэвээр байгаа нь хөгжиж буй болон хөгжил буурай орнуудад сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхэд саад болж байна.
- Санхүүгийн хэрэгслийг төрөлжүүлэх, ялангуяа холимог санхүүжилт (blended finance), баталгаа, эрсдэл хуваалцах механизм, урт хугацааны хямд эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатайг онцолсон байна. Ийм арга хэрэгсэл нь хувийн хөрөнгө оруулалтыг татах, төслийн санхүүгийн эрсдэлийг бууруулах, улмаар сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг илүү тэгш, хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой гэж дүгнэжээ.



Эх сурвалж: International Renewable Energy Agency & Climate Policy Initiative. (2025). Global landscape of energy transition finance 2025 (ISBN: 978-92-9260-692-3). International Renewable Energy Agency.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТУЗ–ИЙН 2026 ОНД АНХААРАХ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 7 ЧИГ ХАНДЛАГА

Компанийн засаглал урьд урьдынхаас илүү өндөр шалгууртай тулгарч байна. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)–үүд 2026 оны босгон дээр эрсдэлийн орчин, зохицуулалтын шаардлага, геополитикийн тодорхойгүй байдал, технологийн хурдацтай өөрчлөлт зэрэг хүчин зүйлс зэрэгцэн өрнөж буй нөхцөлд “үр дүнтэй хяналт” гэж яг юуг ойлгож, түүнд ямар шаардлага тавих вэ гэдгээ дахин тодорхойлох хэрэгтэй болжээ.

ТУЗ–ийн үүрэг, хариуцлага улам нэмэгдсээр байна. Идэвхгүй, мэдээлэл хүлээн авагчийн байр сууринаас хуралд суудаг, улирал тутмын тайлан сонсдог ТУЗ аажмаар халагдаж, өгөгдөлд суурилсан, идэвхтэй оролцоо бүхий стратегийн чиглэлийг тодорхойлж, эрсдэлийг урьдчилан таамаглах, хямралд шуурхай хариу өгөх чадвартай ТУЗ–ийн загвар руу шилжиж байна.

Ингэхдээ ТУЗ–үүд бодит цагийн мэдээлэл, эрсдэлийн удирдлагын нэгдсэн самбар, хиймэл оюун ухаан (цаашид “ХОУ” гэх)–ыг хослуулсан засаглалын платформ ашиглаж эхэлсэн нь шийдвэр гаргалтын чанар, хурдыг мэдэгдэхүйц сайжруулж байна. Нөгөө талаас засаглалын технологид тогтвортой хөрөнгө оруулалт хийж, нэгдсэн дэд бүтэц бүрдүүлсэн компаниудаас гадна хуучинсаг, гар ажиллагаанд түшиглэсэн процессыг одоо ч ашигласаар байгаа компани цөөнгүй. Ийм орчин нь байгууллагын стратегийн уян хатан байдал, эрсдэлийн шуурхай удирдлагыг хязгаарлаж, урт хугацааны өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх ажээ.

Тэгвэл компанийн засаглал 2026 онд болон цаашид хэрхэн хувьсан өөрчлөгдөх вэ? ТУЗ–ийн гишүүд ямар мэдлэг, ур чадварт бэлтгэлтэй байх ёстой вэ? гэсэн асуултад хариулахын тулд дараах үндсэн чиглэлүүдийг авч үзье. Үүнд:

- компанийн засаглалын ирээдүйг тодорхойлох шинэ чиг хандлагууд,
- өнөөгийн засаглалд нөлөөлж буй гадаад орчны (зах зээл, зохицуулалт, технологи) гол хүчин зүйлс,
- дэлхийн зах зээл, хөрөнгө оруулалтын орчинд давамгайлж буй засаглалын чиг хандлага,
- орчин үеийн сорилтыг давахад шаардлагатай засаглалын технологийн дэд бүтэц,

- нарийн төвөгтэй, тогтворгүй орчинд дасан зохицох, өргөжих боломжийг нэмэгдүүлэх засаглалын цогц шийдэл.

Дараах чиг хандлагууд зах зээл, зохицуулалтын шаардлага болон технологийн дэвшил нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, ТУЗ–ийн шийдвэр гаргалтад нөлөөлж байгааг харуулах бөгөөд ийм нөхцөлд хойноос нь гүйцэх биш, “урд нь гарч алхахын” тулд ямар асуудлыг онцгойлон анхаарах ёстойг тодотгож байна.

Чиг хандлага 1. ХОУ–д суурилсан засаглалын платформ – тэргүүлэгчдийг тодруулна

ТУЗ–ийн технологи энгийн цахим платформоос давж, ХОУ–аар баяжуулсан иж бүрэн засаглалын платформ болж хөгжсөн. Энэ нь зөвлөлийн гишүүдэд хуралдаа бэлтгэх, баримт бичгээ системтэй удирдах, эрсдэлийг үнэлж хувилбарын шинжилгээ хийх, стратегийн шийдвэр гаргахдаа тоон ба чанарын мэдээллийг уялдуулахад бодитой дэмжлэг үзүүлдэг. Тэргүүлэгч ТУЗ–үүд ХОУ–ийн гаргасан дүн шинжилгээ, санал дүгнэлтийг мэргэжлийн хүний шүүмжлэлтэй хослуулан ашигласнаар үр ашиг, стратегийн шийдвэрийн чанарыг мэдэгдэхүйц сайжруулж байна.

ХОУ нэвтрүүлэлт нь дэлхий даяар анхаарлын төвд байгаа бөгөөд 2026 оны судалгааны урьдчилсан дүнгээс үзэхэд ТУЗ–ийн түвшинд хэлэлцэх ёстой тэргүүлэх сэдвүүдийн нэг гэж үзжээ. Түүнчлэн, Ази, Номхон далайн бүсийн ТУЗ–ийн гишүүд ч үйл ажиллагаандаа ХОУ–г нэвтрүүлэх асуудлыг 2026 оны гол сэдвийн нэг хэмээн нэрлэсэн байна.

Генератив (жишээ нь ChatGPT гэх мэт) ХОУ–г олон байгууллага ажилдаа туршин нэвтрүүлж эхэлсэн ч түүнийг ашиглах бодлогын баримт бичигтэй компаниудын эзлэх хувь харьцангуй бага хэвээр байна. Энэ нь бодлого, ёс зүйн хүрээг ТУЗ–ийн түвшинд системтэй тогтоох ажил хангалттай хийгдээгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар ХОУ–д суурилсан засаглалын платформ нь зөвхөн томоохон компаниудын давуу тал байхаа больж жижиг, дунд компаниудад ч нэгдсэн мэдээллийн орчин бүрдүүлэх, эрсдэлийн хяналтаа сайжруулах, ТУЗ, гүйцэтгэх удирдлага хоорондын харилцааг илүү чанартай болгох боломжийг олгож байна.

Чиг хандлага 2. Компанийн соёл – санхүүгийн залилан, зөрчилтэй нүүр тулна

Амжилттай, ашигтай ажиллаж буй компанид ч санхүүгийн залилан, ёс бус үйлдэл тохиолдож болно. Сүүлийн үеийн томоохон дуулиануудаас харахад комплайнсын тогтолцоо хэлбэр төдий байх, эрх мэдэл хэт төвлөрсөн үед хяналтын механизм үр дүнгүй болдгийг харууллаа. Иймээс ТУЗ-үүд компанийн соёлыг стратегийн хөрөнгө гэж үзэх, ил тод байдал, нээлттэй харилцааг дэмжсэн соёл бүрдүүлэх, соёлын үзүүлэлтийг тогтмол хэмжиж, шүгэл үлээгчийн (whistleblower) сувгийг бодитоор дэмжиж, удирдлагын зан төлөв, шийдвэр гаргалтыг тогтмол хянах замаар эрсдэлийг эрт илрүүлэхэд анхаарч байна. Түүнчлэн, аливаа хямрал, дуулиант асуудал гарсан үед эхний 72 цагийн хугацаанд мэдээлэл түгээх, хариу арга хэмжээ авах, оролцогч талуудтай харилцах урьдчилсан төлөвлөгөөтэй байх нь компанийн нэр хүнд, санхүү, хууль, эрх зүйн эрсдэлийг бууруулах чухал хэрэгсэл юм.

Ёс зүй, соёлын хариуцлага голчлон гүйцэтгэх удирдлагын түвшинд төвлөрдөг байсан бол одоо үед соёл, ёс зүйн асуудлыг стратегийн зорилго, урамшууллын тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах, удирдлагын ёс зүйн хариуцлагыг илүү тодорхой тогтоох гэх мэт асуудлыг ТУЗ-ийн түвшинд авч үзэх зайлшгүй шаардлагатай болжээ. Судалгааны дүнгээс харахад ёс зүй, ил тод байдлын соёл төлөвшсэн компаниуд урт хугацаанд санхүү, нэр хүндийн хувьд өрсөлдөгчдөөсөө давуу үзүүлэлттэй байна.

Чиг хандлага 3. ХОУ-ийн ёс зүй – гол сэдэв болно

ХОУ-ийг нэвтрүүлэх нь зөвхөн технологийн шинэчлэл төдий бус, ёс зүйн сорилтыг мөн дагуулж байна. ТУЗ-үүд ХОУ-ийн шийдвэрийн үр дагаврыг хариуцах этгээд, өгөгдөл болон алгоритмд үүсэж болох хазайлтыг илрүүлэх, хэрэглэгчийн нууцлал, хүний эрхийн хамгаалалт зэргийг компанийн соёл, эрсдэлийн удирдлагатай уялдуулах механизмыг тодорхойлох ёстой.

Ёс зүй нь зөвхөн хууль, журам мөрдөх асуудал биш юм. Зохицуулалтын орчин тодорхой бус үед зөвхөн хуульд хязгаарлагдахгүйгээр ёс зүйн дүрэм, компанийн үнэт зүйлд тулгуурлан олон нийт, хэрэглэгч, ажилтны итгэлийг хамгаалах байр сууриа тогтоох нь урт хугацааны тогтвортой байдлын үндэс болдог.

ТУЗ нь ХОУ-ийн системээс үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, тэдгээрийг илрүүлж, бууруулах хяналтын механизмыг төлөвлөх, зохицуулагчийн шаардлага, торгууль, хариуцлагын хэмжээг урьдчилан тооцох шаардлагатай. Ингэснээр ХОУ-ийг хариуцлагатай, тогтвортой, урт хугацааны үнэ цэн бий болгох хэрэгсэл болгон ашиглах боломж бүрдэнэ.

Үргэжлэл бий..

Эх сурвалж: www.diligent.com




ФИНТЕК БА РЕГТЕК

2026 ОНЫ ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГА

Финтек салбарын хувьд 2026 он бол хурдацтай өсөлт үзүүлэхээс илүү тогтвортой байх тухай олон улсын шинжээчид онцолж байна. Компаниудын хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дижитал хэлбэрт шилжүүлж байгаа нь тэдний сонголт гэхээс илүү зах зээлийн шаардлага болж байна. Иймд хиймэл оюун ухаан, блокчэйн, кибер аюулгүй байдлын технологиуд нь компаниудын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж, үйл ажиллагааг өөр түвшинд авчирч байна. Энэхүү мэдээллийг “Финтек сонин” – оос эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэлээ.

1. Санхүүгийн үйлчилгээ апп, платформд шингэнэ



Санхүүгийн үйлчилгээг бүтээгдэхүүн, үйлчилгээ дотроо нэгтгэх суурилагдсан санхүүгийн зах зээл 2030 он гэхэд 7.2 их наяд ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Банкууд бүтээгдэхүүнээ шууд борлуулах бус, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч болж хувирах боломжтой.

2. Хиймэл оюун ухаанд суурилсан банкны үйлчилгээ давамгайлна



Санхүүгийн салбарт хиймэл оюун ухаан ашиглах зах зээл 2030 он гэхэд 41 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Одоогийн байдлаар

банк, санхүүгийн байгууллагуудын 75 хувь нь хиймэл оюун ухааныг ямар нэг хэлбэрээр ашиглаж байна. Хиймэл оюун ухаан ашиглан хэрэглэгчийн зан төлөвийг урьдчилан таамаглан зөвлөмж өгөхөөс гадна чатбот уламжлалт салбарын үйлчилгээний тодорхой хэсгийг орлож эхэлнэ.

3. Стэйблкойны хэрэглээ дэлхий даяар өснө



2025 оны эхний хагас жилд стэйблкойн 8.9 их наяд ам.долларын гүйлгээ хийж, нийт шилжүүлгийн хэмжээ 18 их наяд ам.долларт хүрсэн байна.

Стэйблкойн нь крипто зах зээлээс хальж, олон улсын төлбөр

тооцооны бодит хэрэгсэл болж байна. Ялангуяа бизнес хоорондын гадаад шилжүүлэг, токенжуулсан хөрөнгийн гүйлгээнд ашиглах боломж нэмэгдэж, хурд, шимтгэлийн хувьд давуу талтай шийдэл болж байна.

4. Нээлттэй банкнаас нээлттэй санхүү рүү шилжинэ



Нээлттэй банкны систем цаашид зөвхөн дансны мэдээллээр хязгаарлагдахгүй, зээл, даатгал, хөрөнгө оруулалт, тэтгэврийн

мэдээллийг хамарсан нээлттэй санхүүгийн орчин болон өргөжинө. Ингэснээр хэрэглэгчид санхүүгийн бүх мэдээллээ нэг дороос харах боломжтой болно.


5. Крипто, блокчэйний зохицуулалт илүү боловсронгуй болно



Европын холбооны Крипто хөрөнгийн зах зээлийн зохицуулалт (MiCA) зэрэг зохицуулалтууд хэрэгжиж эхэлснээр

крипто зах зээл илүү ил тод, журамтай болно. Энэ нь институцийн хөрөнгө оруулагчдыг татахын зэрэгцээ жижиг хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулахад чиглэж байна.

6. Квант тэсвэртэй кибер аюулгүй байдал чухал болно



АНУ-ын Стандарт ба технологийн үндэсний хүрээлэн (NIST) 2024 онд пост-квант криптографийн стандарт гаргаж,

санхүүгийн байгууллагуудад нэвтрүүлэхийг зөвлөсөн. Квант компьютерийн хөгжилтэй уялдан өнөөгийн шифрлэлтийн аргууд ирээдүйд эрсдэлд орох тул санхүүгийн байгууллагууд пост-квант криптографи нэвтрүүлэх шаардлагатай болж байна. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлыг урт хугацаанд хангах зорилготой.

7. Тогтвортой, ногоон санхүүжилт тэлнэ



Сайн тогтвортой санхүүгийн сангуудын урсгал 2025 онд 4.9 тэрбум ам.долларт хүрсэн. Нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, БОНЗ-ын шалгуурт нийцсэн санхүүжилтэд чиглэсэн финтек шийдлүүд нэмэгдэнэ. Хэрэглэгчид ногоон хөрөнгө оруулалт хийх сонирхолтой болж, банк, финтекүүд энэ мэдээллийг илүү ил тод харуулах хандлагатай байна.

8. Төв банкны дижитал валют (CBDC)-ийн хэрэглээ нэмэгдэнэ



Олон улс Төв банкны дижитал валютыг туршилтаас бодит хэрэглээнд шилжүүлж эхэлнэ. Дижитал фунт, дижитал евро зэрэг төслүүд улам түгээмэл болж, хилийн чанад дахь төлбөрийг илүү хурдан, зардлыг багасгаж гүйцэтгэх боломжийг олгож байна.

9. Финтек салбарын нэгтгэл эрчимжинэ



2024 онд дэлхийн финтек хөрөнгө оруулалт 12%-иар буурч, томоохон компаниуд ашиггүй стартапыг худалдан авч нэгтгэх хандлагатай болсон. Хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор ашиггүй финтекүүд зах зээлээс гарах эсвэл томоохон банк, корпорацид нэгдэн шингэх хандлага нэмэгдэнэ. Үүний үр дүнд салбар илүү цэгцтэй болно.

10. Бодит цагийн төлбөр (Real-Time Payments) дэлхийн стандарт болно



Мөнгө шилжүүлэхэд удаан хүлээх ойлголт алга болж, бодит цагийн төлбөр хэвийн стандарт болно. Хэрэглэгчид мөнгөний урсгалаа шууд хянах, хурдан, ил тод гүйлгээ хийх боломж улам нэмэгдсээр байна.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/>

СУДЛААЧИЙН ИНДЭР

САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ БА ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хороо, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга Б.Батчимэг /Batchimeg_b@frc.mn/

Санхүүгийн зохицуулах хороо, ЗЗСХГ, Сэндбоксын албаны ахлах мэрэжилтэн Э.Элбэгзаяа /Elbegzaya@frc.mn/

Санхүүгийн зохицуулах хороо, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн О.Мичидмаа /Michidmaa_o@frc.mn/

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол Улсын санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ, түүнийг дагасан зохицуулалтын орчны бэлэн байдлыг үнэлж, улс орнууд хиймэл оюун ухааны хэрэглээг хэрхэн зохицуулж, ямар бодлого баримталж буйг судлахыг зорилгоо. Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын 30 орчим хувь нь хиймэл оюун ухааныг ашиглаж буй бөгөөд дийлэнх хувь нь ойрын жилүүдэд хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөж буйгаа илэрхийлсэн. Мөн хиймэл оюун ухааныг голчлон хэрэглэгчийн үйлчилгээ, зээл, эрсдэлийн үнэлгээнд ашиглаж байна. Улс орнууд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоо технологи нейтрал буюу аливаа эрсдэлийг ашиглаж буй технологиос нь үл хамааран зохицуулж чадаж буй эсэхэд анхаарал хандуулан шаардлагатай тохиолдолд нэмэлт зөвлөмжүүдийг боловсруулах зохицуулалтын чиг хандлагыг баримталж байна. Манай улсын хувьд хувь хүний өгөгдлийн нууцлал, ашиглалт, кибер аюулгүй байдалд холбогдох зохицуулалтууд байгаа хэдий ч засаглалын хариуцлага, гуравдагч талын эрсдэл болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж буй загвар, технологийн тайлбарлах хуульчилсан байдалд хяналт, зохицуулалт тавих тогтолцоо сул байна. Иймд зохицуулалтын журам, зааварт холбогдох өөрчлөлтийг оруулах, мөн хиймэл оюун ухааны ёс зүйтэй ашиглалтын талаар зөвлөмж, мэдээллийг салбарын оролцогч болон олон нийтэд хүргэж, шинэ технологийн хөгжүүлэлт, ашиглалтын талаар мэдээллийн сан бүрдүүлж ашиглах шаардлагатай байна.

УДИРТГАЛ

Хиймэл оюун ухаан нь 1950–иад оноос үүсэлтэй боловч компьютерийн тооцооллын хүчин чадал, өгөгдлийн огцом өсөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, санхүүгийн салбарт өргөн хүрээнд нэвтэрч байна. Ялангуяа банк, санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухааныг хэрэглэгчийн үйлчилгээ, зээлийн эрсдэлийн үнэлгээ, андеррайтинг, эрсдэлийн менежмент болон арын оффисын үйл ажиллагаанд идэвхтэй ашиглаж байна. Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын судалгаагаар банкны салбар нь хиймэл оюун ухааныг хамгийн өргөн ашиглаж буй салбар бөгөөд Европын холбооны орнуудын банкуудын 95 хувь нь уг технологийг үйл ажиллагаандаа ашиглаж, хөгжүүлж байна (Organisation for Economic Co–Operation and Development [OECD], 2024).

Хэдийгээр хиймэл оюун ухаан нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үйлчилгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой боловч кибер аюулгүй байдлын эрсдэл, зах зээлийг урвуулан ашиглах, мэдээллийн алдаа, хуурамч дүр, дуу, дүрс ашигласан залилан, алдаатай тооцооллоос үүдэлтэй ташаа мэдээлэл түгээх зэрэг эрсдэлүүдийг дагуулж байна (OECD, 2024). Мөн хиймэл оюун ухааны “хар хайрцаг” шинж чанар нь тооцооллын үр дүнг бүрэн тайлбарлах боломжийг хязгаарлаж, алдааны шалтгааныг тогтоох, хяналт тавихад хүндрэл учруулдаг (OECD, 2024).

Түүнчлэн санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухааныг ихэвчлэн гуравдагч технологийн компаниудаар дамжуулан нэвтрүүлж байгаа нь үйл ажиллагааны эрсдэл, гуравдагч талаас хэт хамаарах байдал бий болгох, мөн эдгээр технологийн

үйлчилгээ үзүүлэгчид санхүүгийн зохицуулагч байгууллагын шууд хяналтад хамрагддаггүйтэй холбоотойгоор зохицуулалтын эрсдэлийг нэмэгдүүлж байна (OECD, 2024). Монгол Улсын хувьд банк, санхүүгийн салбарт технологийн дэвшил эрчимтэй нэвтэрч байгаа хэдий ч хиймэл оюун ухааны ашиглалтын талаарх албан ёсны мэдээлэл, мөн тусгайлсан зохицуулалтын журам, заавар одоогоор бүрдээгүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагууд технологийн дэвшлийг хурдтай нэвтрүүлж төрөл бүрийн цахим технологид суурилсан финтек үйлчилгээнүүдийг хэрэглэгчдэд санал болгож байгаа хэдий ч санхүүгийн байгууллагуудын хөгжүүлж буй технологи, хиймэл оюун ухааны ашиглалтын талаар албан ёсны тоо, баримт болон санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны ашиглалттай холбоотой зохицуулалтын журам, заавар байхгүй байна.

Энэхүү судалгаа нь санхүүгийн байгууллагуудын хиймэл оюун ухааны ашиглалтын талаар мэдээлэл цуглуулах мөн хиймэл оюун ухааныг санхүүгийн салбарт ашигласнаар үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, улс орнууд хиймэл оюун ухааны зохистой хэрэглээний талаар ямар бодлого баримталж, хэрхэн зохицуулж буйг судлах зорилготой. Судалгаа нь нийт 5 бүлэгтэй ба дараагийн бүлэгт санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ болон эрсдэлийг тодорхойлох бол гуравдугаар бүлэгт хиймэл оюун ухааны зохицуулалт олон улсад хэрхэн хэрэгжиж буйг судалсан. Дөрөвдүгээр бүлэгт санхүүгийн байгууллагуудаас авсан хиймэл оюун ухааны хэрэглээний талаарх түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн, Монгол Улсад хиймэл оюун ухааны эрсдэлийг хэрхэн зохицуулж буй судалсан бол сүүлийн бүлэгт судалгааны дүгнэлт, саналыг боловсруулсан.

II. ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ БА ЭРСДЭЛ

2.1. Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ ба тулгамдсан эрсдэл

Санхүүгийн салбарт хиймэл оюун ухаанд чиглэсэн хөрөнгө оруулалт хурдацтай өсөж байгаа бөгөөд 2023 онд 35 тэрбум ам.долларт хүрсэн уг үзүүлэлт 2027 он гэхэд 97 тэрбум ам.доллар болж нэмэгдэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухааныг гол бизнесийн үйл ажиллагаанд бус, дотоод үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү ашиглаж байгаа нь зохицуулалтын тодорхой бус байдал, ёс зүй, өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, өгөгдлийн ил тод, тэгш хүртээмж болон хиймэл оюун ухааны загварын тайлбарлагдахуйц байдлын эрсдэлтэй холбоотой юм (Basel Committee on Banking Supervision [BCBS], 2024).

Хиймэл оюун ухаан нь хэрэглэгчийн үйлчилгээний салбарт хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд чатботуудын тусламжтайгаар хүний нөөцийн зардлыг бууруулах, 24/7 тасралтгүй үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж байна. Чатботын хэрэглээ нь энгийн мэдээлэл өгөхөөс эхлэн хувь хэрэглэгчид тохирсон үйлчилгээ санал болгох, зээлийн өргөдөл гаргах, санхүүгийн гүйлгээ гүйцэтгэх хүртэл өргөжсөн байна. Судалгаагаар АНУ-ын хүн амын 37 хувь нь 2022 онд банкны чатботтой харилцсан бөгөөд цаашид чатбот, робо зөвлөхийн хэрэглээ улам нэмэгдэх хандлагатай байна (Consumer Financial Protection Bureau [CFPB], 2023).

Мөн хиймэл оюун ухааныг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд сэжигтэй гүйлгээг илрүүлэх, цахим луйврыг бууруулахад өргөн ашиглаж байна. Үүнээс гадна гүйлгээний мэдээлэлд суурилан хэрэглэгчийн зан төлөвийг тодорхойлох замаар эрсдэлийн хяналтыг илүү нарийвчлан хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Андеррайтингийн салбарт хиймэл оюун ухааны хэрэглээ, ялангуяа даатгалын салбарт эрчимтэй өсөж, бүтэцлэгдсэн болон бүтэцлэгдээгүй өгөгдлийг ашиглан эрсдэлийн үнэлгээ, даатгалын хураамжийг оновчтой тогтооход ашиглагдаж байна.

Гэсэн хэдий ч санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээний талаарх нэгдсэн, албан ёсны статистик мэдээлэл хомс хэвээр байна. Олон улсын болон судалгааны байгууллагууд түүвэр судалгаагаар мэдээлэл цуглуулж байгаа бол зохицуулагч байгууллагууд хяналт шалгалт, салбарын уулзалт, зах зээлийн тойм, инновацийн хөтөлбөрүүдээр дамжуулан мэдээлэл авч байна (Organisation for Economic Co-Operation and Development [OECD], 2024).

2.2. Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны эрсдэл

Хүснэгт . Хиймэл оюун ухааны санхүүгийн салбар дахь ашиглалттай холбоотой эрсдэлүүд

Эрсдэлийн төрөл	Тайлбар
Зээлийн эрсдэл	Зээлийн чанаргүйдэх эрсдэлийн магадлалыг дутуу тооцоолох;
Загварчлалын эрсдэл	Өгөгдөлд орсон өөрчлөлтийг загвар тусгаж чадахгүй байхаас үүдэн загварын үр дүн буруу гарах; Загварыг тайлбарлаж чадахгүйгээс үүдэн тухайн загварын үнэн зөв, найдвартай байдлыг техникийн болон онолын талаас нь үнэлж чадахгүй байх; Загварыг хэт их сургах эсхүл дутуу сургаснаас үүдэн загварын алдаа гарах, өөрөөр хэлбэл загварын үр дүнг бусад төрлийн нөхцөл байдалд нийцүүлж чадахгүй байх эсхүл хэтэрхий энгийн сургагдаж өгөгдөл дэх хэв шинжийг тодорхойлж чадахгүй байх; Өгөгдлийн чанараас үүдэн алдаатай хариу эсхүл алдаатай хамаарал ажиглагдах буюу буруу төөрөгдсөн үр дүн гарах (hallucination); Хиймэл оюун ухааны чадавхыг хэт өндөр үнэлснээс үүдэн загварын боломжоос хэтийдсэн зорилгоор ашиглах; Өгөгдөл мэдээллийг тогтмол шинэчилж чадахгүйгээс үүдэн хиймэл оюун ухааны загварууд нь найдвартай таамаглал гаргаж чадахгүй байх;
Кибер эрсдэл	Байгууллагууд нь олон төрлийн системд холбогдох олон төрлийн гадны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтрах ажиллах үед кибер эрсдэл хүлээн авах суваг нэмэгддэг; Хангалттай хандалтын хяналтыг хэрэгжүүлээгүйн улмаас хиймэл оюун ухааны загвар болон сургагдсан өгөгдөлд зөвшөөрөлгүй хандах; Өгөгдлийг урвуулан ашиглах замаар хиймэл оюун ухааны үр дүнг гажуудуулах, өөр чиглэлд ашиглах зорилготой халдлагуудад хиймэл оюун ухаан нь өртөмтгий байдаг; Хиймэл оюун ухааны загварыг алхам бүрийг нь асуух байдлаар ижил ажилладаг загвар бүтээн хулгайлах эрсдэл байдаг;
Үйл ажиллагааны эрсдэл	Хуучин үеийн мэдээллийн технологийн системтэй байгууллагуудын хувьд технологийн архитектортоо нэмэлтээр хиймэл оюун ухааны цогц хөгжүүлэлтийг хийснээр системийн уналт зэрэг үйл ажиллагааны эрсдэлийг нэмэгдүүлдэг; Хиймэл оюуны хөгжүүлэлт дээр гуравдагч талыг ашиглаж буй байгууллагуудын хувьд хөндлөнгийн этгээдээс үйл ажиллагаа нь хамааралтай болох, чухал үйл ажиллагаа нь доголдох үед бие даан шийдвэрлэх боломжгүй байх эрсдэл үүсдэг; Хиймэл оюун ухааны системийн хурдтай шинэчлэлээс үүдэн эрсдэлийн хяналтын үйл ажиллагаа хурдан хугацаанд хоцрогдох эрсдэлтэй;
Хэрэглэгчийг хамгаалах үйл ажиллагааны эрсдэл	Шударга бус үнэ тогтоох зорилгоор хэрэглэгчийн эмзэг мэдээллийг ашиглах; Ялгаатай, гажуудалтай өгөгдөл, мэдээлэлд суурилан нийгмийн тодорхой бүлэг, хүн амыг хассан тэгш бус шийдвэр гаргах, ялгаатай өгөгдөлд суурилсан тооцоолол цааш улам бүр үргэлжлэн дэлгэрэх; Хэрэглэгчийн эрсдэлийг нарийвчлан тооцоолохын хэрээр эрсдэл өндөртэй бүлэгт хамаарах хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээний хүртээмжээс хасагдах эрсдэл нэмэгдэх; Өрсөлдөгчдийн үнийн өөрчлөлтөд мэдрэг, автоматжуулсан үнэ тохируулах систем ашиглаж эхэлснээр зах зээлд хуйвалдааны үнэ үүсэх;
Сүргийн зан төлвийн эрсдэл	Санхүүгийн байгууллагууд ижил өгөгдөл, ижил хиймэл оюун ухааны загвар ашиглах үед мөчлөг дагасан шийдвэр гаргалт улам бүр нэмэгдэх эрсдэлтэй; Санхүүгийн байгууллагууд системийн хувьд гажуудалтай шийдвэр гаргах, хөрөнгийн үнэлгээ буруу тогтох зэрэг эрсдэлтэй;
Холбоо хамаарлын эрсдэл	Нэг ижил технологийн байгууллагаар үйлчлүүлж байгаа санхүүгийн байгууллагуудын тоо нэмэгдэхийн хэрээр гуравдагч талын үйл ажиллагаа доголдох, кибер халдлагад өртөх зэрэг үед системийн хэмжээний эрсдэл үүсэж болзошгүй эмзэг байдалд хүрэх;
Хар хайрцагны эрсдэл	Хиймэл оюун ухааны загварын үл тайлбарлагдах байдал, хар хайрцагны эрсдэл нь тухайн байгууллагын үр дүнтэй эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэхэд эрсдэл үүсгэдэг;
Өрсөлдөөний эрсдэл	Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх зардлаас үүдэн зөвхөн томоохон санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглах замаар зах зээлд төвлөрөл үүсэх, өрсөлдөөн буурах эрсдэлтэй.

Санхүүгийн салбарт хиймэл оюун ухааныг ашигласнаар цоо шинэ төрлийн эрсдэл үүсэхээс илүүтэйгээр санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах өмнөх эрсдэлүүдийн хамрах хүрээ, тохиох давтамж нэмэгдэнэ хэмээн судлаачид үзэж байна. Хэдийгээр хиймэл оюун ухааны тусламжтайгаар санхүүгийн луйвар, залилан, кибер халдлагуудыг илрүүлэх чадамж урьд өмнө нь байгаагүйгээр нэмэгдэж байгаа ч нөгөө талд кибер гэмт хэрэгтнүүд мөн хиймэл оюун ухааны тусламжтайгаар илүү нарийн төвөгтэй зохион байгуулалттай халдлагуудыг гүйцэтгэх магадлал нэмэгдэж буй аж (BIS, 2024). Мөн гуравдагч талаас хамааралтай байдлын эрсдэл улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд санхүүгийн бус томоохон технологийн компаниуд өөрсдийн давуу талаа ашиглан зах зээлд монопол байдлаар оролцох эрсдэл нэмэгдэж байгаа нь санхүүгийн зохицуулалтын тулгамдсан асуудал болж байна.

III. ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД

Улс орон бүр хиймэл оюун ухааны хэрэглээ болон эрсдэлтэй холбоотой өөр, өөр төрлийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлж буй бөгөөд зарим улс орон хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой салбар дамнан хамарсан ерөнхий хууль гаргаж байгаа бол зарим нь зөвхөн санхүүгийн зах зээл дэх хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулахад чиглэсэн дүрэм, журам эсхүл заавал мөрдөх шаардлагагүй зааварчилгаа, зөвлөмжийг боловсруулах зэргээр ажиллаж байна.

Тухайлбал Европын холбоо, Бразил, Чил, Колумб, Перу зэрэг улс орнууд хиймэл оюун ухааны ерөнхий зохицуулалт, хууль, тогтоомж батлах байдлаар хэрэгжүүлж байна. Харин цөөн хэдэн санхүүгийн зохицуулагч байгууллагуудыг үл тооцвол санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулсан зохицуулалт ховор байна. Үүний нэг шалтгаан нь хиймэл оюун ухаанд хамаарах олон төрлийн эрсдэлүүд нь зөвхөн хиймэл оюун ухаанаас үүдэн шинээр үүсэхээс илүүтэйгээр өмнө нь байсан эрсдэлүүд нь технологийн нөлөөгөөр нэмэгдэх, эсхүл өөр хэлбэрээр үүсэхтэй холбоотой юм. Мөн санхүүгийн салбар дахь дийлэнх зохицуулалт эдгээр санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийг хэрэглэж буй технологиос нь үл хамааран зохицуулж байдаг. Тухайлбал, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, хэрэглэгч, хөрөнгө оруулагчийг хамгаалах зохицуулалт, эрсдэлийн удирдлага, мэдээллийн болон кибер аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам нь ашиглагдаж буй технологиос нь үл хамааран санхүүгийн үйл ажиллагаа холбогдох эрсдэлүүдийг зохицуулж байдаг.

Улс орны санхүүгийн зохицуулагч байгууллагууд өөрсдийн ашиглаж буй зохицуулалтын журам, заавар нь хиймэл оюун ухаанаас үүдэж буй эрсдэлийг хамарч чадаж буй судалгааг гүйцэтгэх тохиолдол байна. Тухайлбал, Английн Төв банк болон Английн санхүүгийн зохицуулагч байгууллага нь 2022 онд хүчин төгөлдөр ашиглагдаж буй зохицуулалтын дүрэм, журам нь хиймэл оюун ухаан болон машин сургалтад хамаарах эрсдэлийг зохицуулж чадаж буй эсэхийг үнэлсэн судалгааг гүйцэтгэсэн (Bank of England, 2022). Судалгааны үр дүнд засаглал болон эрсдэлийн менежментэд хамаарах зохицуулалтын хувьд хиймэл оюун ухааны хэрэглээнээс үүдэж болзошгүй эрсдэлийг хангалттай тусгасан бол эрсдэлийн үнэлгээний дүрэм, журмуудад шинэ тутам хөгжиж буй хиймэл оюун ухааны хэрэглээтэй нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан (Bank of England, 2023).

АНУ-ын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2023 оны жилийн тайланд банк, санхүүгийн салбарт ашиглагдаж буй зохицуулалтын журам, зааврууд хиймэл оюун ухааны хэрэглээ, үүдэх эрсдэлийг хамарч чадаж буй эсэхийг мөн үнэлсэн бөгөөд эрсдэлийн менежментийн журам заавар нь ашиглаж буй технологиос нь үл хамааран холбогдох эрсдэлүүдийг тусгасан, зохистой зээлийн зарчим зэрэг салбарын тодорхой асуудлуудад чиглэсэн зохицуулалтууд нь хиймэл оюун ухааны хэрэглээнээс үүдэж болзошгүй эрсдэлүүдэд мөн тохирсон байгааг дурдсан (FSOC, 2023).

Судалгааны энэхүү бүлэгт санхүүгийн салбарын хөгжлөөр тэргүүлэгч АНУ, Англи, Сингапур, Өмнөд Солонгос, Япон, Европын холбооны улсууд болон манай улстай хөгжлийн түвшин ойролцоо, төв ази, зүүн өмнөд азийн улс орнууд хиймэл оюун ухааныг хэрхэн зохицуулж буй талаар судалсан. Мөн олон улсын байгууллагуудын зүгээс санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны зохицуулалтын талаар баримталж буй бодлогын талаар мөн энэхүү бүлэгт тусгасан.

Хүснэгт . Улс орнуудын зохицуулалтыг харьцуулсан байдал

Улс	Зохицуулалтын төрөл	Заавал дагаж мөрдөх эсэх	Хамарсан салбарууд	Тусгасан гол зохицуулалтын хүрээ
Европын холбоо	Нэгдсэн хуулийн зохицуулалт	Заавал дагаж мөрдөх	Эрсдэл өндөртэй санхүүгийн үйл ажиллагаа	Засаглал, ил тод байдал, хүний хяналт, эрсдэлийн удирдлагатай холбоотой зохицуулалт
АНУ	Тухайлсан хуульгүй, заавар, зөвлөмжид суурилсан	Хосолмол	Санхүүгийн бүхий л салбаруудыг хамарсан	Засаглал, тэгш, хүртээмжтэй байдал, тайлбарлагдахуйц байдал
Англи	Тухайлсан хуульгүй, заавар, зөвлөмжид суурилсан	Хосолмол	Санхүүгийн бүхий л салбаруудыг хамарсан	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хариуцлага хүлээх, аюулгүй байдал, ил тод, тэгш хүртээмжтэй байдал
Сингапур	Заавар зөвлөмжид суурилсан	Шаардлагагүй	Зохицуулалттай салбаруудыг хамарсан	Ил тод, ёс зүйтэй, хариуцлагатай байдал
Өмнөд Солонгос	Заавар зөвлөмжид суурилсан, сэндроксын зохицуулалт	Шаардлагагүй	Санхүүгийн бүхий л салбаруудыг хамарсан	Кибер аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалт, засаглал болон өөрийгөө зохицуулах механизм
Япон	Заавар зөвлөмж боловсруулж буй	Шаардлагагүй	Санхүүгийн бүхий л салбаруудыг хамарсан	Хэлэлцүүлгийн шатанд буй
Казахстан	Хууль батлуулахаар ажиллаж буй	Заавал дагаж мөрдөх	Эрсдэл өндөртэй санхүүгийн үйл ажиллагаа	Ил тод байдал, хүний оролцоо ба хариуцлага, ёс зүйтэй хэрэглээ

IV.МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс 2024 онд “Хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс”-ээр 11 байр урагшилж, 188 орноос 98 дугаарт эрэмбэлэгдсэн талаар Oxford Insight байгууллагын гаргасан судалгаанд дурджээ. Хиймэл оюун ухааны бэлэн байдлын индексийг гаргахдаа Засаглал, технологи, өгөгдөл ба дэд бүтэц гэсэн үндсэн 3 шалгуурын хүрээнд 10 үзүүлэлтийг хамруулдаг ба дэлгэрэнгүй статистик мэдээллээс харахад, Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үзүүлэлт жил ирэх бүр тодорхой хэмжээнд өсөлттэй байгаа ч “алсын хараа” байхгүй буюу 0 үнэлгээ авч байгаа нь тус индексийг хойш татах шалтгаан болж байна.

Монгол Улсын хувьд хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой хууль тогтоомж, нэгдсэн зохицуулалт хараахан бүрдээгүй байгаа хэдий ч Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Хиймэл оюун ухааны үндэсний стратеги”-ийн төслийг боловсруулах, холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байна.

4.1.Санхүүгийн байгууллагуудын хиймэл оюун ухааны ашиглалт

Санхүүгийн салбарын хувьд хиймэл оюун ухааны ашиглалттай холбоотой нэгдсэн тоон мэдээлэл, статистик мэдээллийн сан бүрдээгүй байгаа тул санхүүгийн байгууллагуудын хиймэл оюун ухааны хэрэглээг судлах зорилгоор түүвэр судалгаа гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийг технологид суурилсан үйлчилгээ үзүүлдэг 140 санхүүгийн байгууллагад хүргүүлснээс 75 байгууллага нь судалгаанд хамрагдсан байна.

Ерөнхий мэдээлэл: Судалгаанд нийт 75 санхүүгийн байгууллага хамрагдсанаас 31 буюу 41.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллага, 19 буюу 25.3 хувь нь үнэт цаасны компани, 10 буюу 13.3 хувь нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компани,

мөн 10 буюу 13.3 хувь нь ердийн даатгалын компани, 3 буюу 4 хувь нь санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага байсан бол арилжаа эрхэлдэг 1 байгууллага болон хамтын санхүүжилтийн 1 компани тус тус судалгаанд оролцсон.


Хиймэл оюун ухааны хэрэглээ: Судалгаанд оролцсон 75 байгууллагаас 53 буюу 70.6 хувь нь хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа ашигладаггүй бол 22 буюу 29.4 хувь нь хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Хиймэл оюун ухааны ашиглалтын чиглэл:



Үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн ашиглаж буй 22 санхүүгийн байгууллагуудын хувьд 41 хувь нь хиймэл оюун ухааныг хэрэглэгчийн үйлчилгээ (чатбот, виртуал туслах гэх мэт)-д, 36 хувь нь эрсдэлийн үнэлгээ болон зээлийн үнэлгээ, оноонд, 23 хувь нь мөнгө угаахтай тэмцэх хяналтыг хэрэгжүүлэх, хэрэглэгчийг танихад ашиглаж байна.

Хиймэл оюун ухааныг ашигласнаар танай байгууллагад гарч буй үр дүн:



Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд, хиймэл оюун ухааныг ашигласнаар байгууллагуудын 26 хувь нь хэрэглэгчийн үйлчилгээ сайжирсан, 24 хувь нь зардал буурсан гэж үнэлсэн байна. Харин 19 хувь нь байгууллагын нийт үр ашиг нэмэгдсэн, 18 хувь нь эрсдэлийн менежмент сайжирч, 7 хувь нь комплаенсын хяналтыг автоматжуулсан, 6 хувь нь орлогыг нэмэгдүүлсэн зэрэг үр дүнг дурджээ.

Судалгаанд хамрагдсан санхүүгийн байгууллагуудын хариултаас үзэхэд, хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд хамгийн том хүндрэл нь боловсон хүчний дутагдал байгааг нийт байгууллагын 45 хувь нь тодорхойлсон. Үүний дараагаар өгөгдлийн нууцлал болон аюулгүй байдлын асуудлыг 16 хувь, өндөр зардлыг 15 хувь, хиймэл оюун ухааны стратеги, бодлого байхгүй байдал 15 хувь нь, мөн зохицуулалтын болон комплаенсын асуудлыг 9 хувь нь гол бэрхшээл хэмээн нэрлэсэн байна.

Кибер аюулгүй байдлын бодлого: Судалгаанд оролцсон санхүүгийн байгууллагуудын дийлэнх нь буюу 76 хувь (57 байгууллага) нь кибер аюулгүй байдлын бодлого, журамтай байна. Мөн судалгаанд оролцсон санхүүгийн байгууллагуудын дийлэнх нь ISO27001 олон улсын стандартыг мөрдөн ажиллаж байна. Тодруулбал, давхардсан тоогоор 55 байгууллага ISO

27001 стандартыг хэрэгжүүлдэг бол 39 байгууллага нь Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж байгаа гэж хариулжээ. Мөн 3 байгууллага PCI DSS (төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын стандарт), 2 байгууллага нь АНУ-ын NIST (Үндэсний стандарт, технологийн хүрээлэн)-ийн стандартуудыг дагаж мөрддөг байна.

4.2. Салбарын зохицуулалтын журам, зааварт хийсэн шинжилгээ

Санхүүгийн салбарт хиймэл оюун ухаан ашиглагдсанаар шинэ төрлийн эрсдэл үүсгэхээс илүүтэйгээр одоо байгаа эрсдэлүүдийг нэмэх хандлагатай байгааг судлаачид онцолж буй бөгөөд улс орнууд санхүүгийн үйл ажиллагаанд тулгарч буй эрсдэлийг ашиглаж буй технологиос нь үл хамааран адил шаардлагыг тавих технологийн хувьд нейтрал зохицуулалтыг ашиглаж байна. Мөн улс орнууд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтын дүрэм, журам нь хиймэл оюун ухааны ашиглалтаас үүдэж болзошгүй эрсдэлийг зохицуулж чадаж буй эсэхийг судалж байгаа бөгөөд энэхүү хэсэгт манай зохицуулалтын дүрэм журмуудад шаардлагатай заалтууд туссан эсэхийг энгийн шалгуураар шалгаж, товч дүгнэлт хийсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын баримт бичгүүдийн хувьд нейтрал буюу технологийн төрлөөс үл хамааран нийтлэг шаардлага тавих зохицуулалтыг зарим хэмжээнд хэрэгжүүлж байгаа ч шинэ технологийн хэрэглээнээс үүдэлтэй эрсдэлүүдийг системтэйгээр тусгасан нарийн зохицуулалт хангалтгүй байна. Компанийн засаглал, загварын эрсдэл, гуравдагч талын эрсдэл, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт зэрэг хэд хэдэн чухал чиглэлд шинэ технологи, түүний хэрэглээнд хамаарсан тодорхой заалт дутмаг байна. Харин өгөгдлийн нууцлал, кибер аюулгүй байдал, хянан шалгагчийн эрх зэрэг чиглэлд хууль, журамд тодорхой зохицуулалтууд туссан байна. Одоо байгаа зохицуулалтын зарим хэсэг нь хиймэл оюун ухааны ашиглалттай холбоотой эрсдэлүүдийг бүрэн бус ч тодорхой хэмжээнд хамаарч чадаж байгаа боловч, цаашид тусгайлан хиймэл оюун ухаан, шинэ технологийн ашиглалттай холбоотой зохицуулалтын заалтуудыг нэмж тусгах, хэрэглэгч болон гуравдагч талын эрсдэлийн менежментэд илүү анхаарах шаардлагатай байна.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

- Хиймэл оюун ухаан санхүүгийн салбарт эрчимтэй нэвтэрч байгаа нь олон улс орны жишээнээс харагдаж байна. Технологийн дэвшил, өгөгдлийн хэмжээний болон тооцоолох чадварын өсөлт нь хиймэл оюун ухааны хөгжлийг хурдасгаж, санхүүгийн байгууллагууд хэрэглэгчтэй харилцах, эрсдэл үнэлэх, арын оффисын автоматжуулалт зэрэгт түгээмэл ашиглаж байна. Зарим улс орнууд хиймэл оюун ухааныг зохицуулах нэгдсэн хуулийг баталж, боловсруулж эхэлсэн ч дийлэнх улс орнууд хиймэл оюун ухааныг зохицуулах нарийвчилсан хууль, журам гаргахаас илүүтэйгээр технологийн төрөлд үл хамаарах буюу технологи нейтрал зарчимд тулгуурласан зохицуулалтыг түлхүү ашиглаж, нэмэлт заавар, зөвлөмжийг гаргах байдлаар ажиллаж байна. Энэ нь хиймэл оюун ухаан тодорхой шинэ төрлийн эрсдэл үүсгэх биш, хуучин эрсдэлүүдийн шинж чанар, цар хүрээ, давтамжийг өөрчилж байгаатай холбоотой юм.
- Монгол Улсын санхүүгийн салбарт хиймэл оюун ухааны хэрэглээ одоогоор харьцангуй эхний шатандаа байгаа боловч судалгаанд хамрагдсан байгууллагуудын тодорхой хувь нь хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, цаашид бодлого, стратеги боловсруулах, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээр төлөвлөж буй нь санхүүгийн байгууллагуудын технологид суурилсан дэвшлийг нэвтрүүлэх, ашиглах сонирхол их байгааг харуулж байна. Хэрэглээний хувьд чатбот, зээлийн оноо, мөнгө угаахтай тэмцэх хяналтын чиглэл давамгайлж байна.
- Мөн байгууллагуудын хувьд хиймэл оюун ухааныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд хиймэл оюун ухаантай холбоотой нэгдсэн бодлого, стратеги байхгүй байгаа нь урт хугацааны чиглэл, хариуцлага, зохион байгуулалтын тогтолцооны дутагдалд хүргэж байна. Хоёрдугаарт, хүний нөөцийн чадавх, технологийн мэдлэг, сургалт хангалтгүй байгаагаас шалтгаалж хиймэл оюун ухаан нэвтрүүлэх процесс удааширч, зөв хэрэглээ хангагдаж чадахгүй байна. Гуравдугаарт, өгөгдлийн чанар, өгөгдлийн нууцлал болон мэдээллийн аюулгүй байдлын асуудлууд нь хиймэл оюун ухааны загваруудын үр дүнд сөргөөр нөлөөлж, зарим тохиолдолд хэрэглэгчийн итгэлцэлд эрсдэл учруулах нөхцөл бүрдүүлж байна.

- Нөгөө талаас санхүүгийн зохицуулалтын орчинд хиймэл оюун ухаантай холбоотой тодорхой эрсдэлүүдийг тусгасан зохицуулалт хязгаарлагдмал байна. Кибер аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалт зэрэг ерөнхий зохицуулалт байгаа хэдий ч засаглалын хариуцлага, загварын тайлбарлагдах байдал, гуравдагч талын эрсдэл, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт зэрэг олон улсын түвшинд онцолж буй чухал асуудлуудыг системтэй тусгасан зохицуулалт байхгүй байна.
- Монгол Улсын хувьд хиймэл оюун ухааныг санхүүгийн салбарт зохистой, үр ашигтай, аюулгүй байдлаар нэвтрүүлэхийн тулд төр, зохицуулагч байгууллага, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ойлголцол, чадавх сайжруулалт, зохицуулалтын шинэчлэл зэрэг олон талт хүчин чармайлт шаардлагатай байна. Хэрэв энэ чиглэлд уялдаатай, эрсдэлд суурилсан, уян хатан бодлогын зохицуулалтыг хөгжүүлж чадвал хиймэл оюун ухаан нь Монголын санхүүгийн тогтолцоонд шинэ шатны өсөлт, хүртээмж, үр ашгийг авчрах бүрэн боломжтой юм.
- Судалгааны үр дүнд үндэслэн санхүүгийн салбарт хиймэл оюун ухааныг зохистой, аюулгүй, хариуцлагатай нэвтрүүлэхийн тулд санхүүгийн байгууллагуудад ёс зүйтэй хэрэглээний нэгдсэн зөвлөмж боловсруулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтыг технологи ньютрал зарчимд нийцэж буй эсэхээр үнэлэх, хяналт шалгалтад загварын эрсдэл, тайлбарлагдахуйц байдал, өгөгдлийн чанарын шалгуурыг тусгах, байгууллагын засаглалд технологиос үүдсэн эрсдэл ба хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, гуравдагч этгээдийн эрсдэлийн удирдлагын шаардлага тогтоох, олон улсын стандартуудыг дагаж мөрдөхийг дэмжих, шинэ технологийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, мөн хиймэл оюун ухааны хэрэглээ, эрсдэл, хэрэглэгчийн эрх болон өгөгдөл хамгаалалтын талаарх олон нийтийн мэдлэгийг системтэйгээр нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖ

- Bank of England. (2022). Artificial Intelligence and Machine Learning. Retrieved from <https://www.bankofengland.co.uk/prudential-regulation/publication/2022/october/artificial-intelligence>
- Bank of England. (2023). Artificial Intelligence and Machine Learning: Feedback Statement FS2/23. Retrieved from <https://www.bankofengland.co.uk/prudential-regulation/publication/2023/october/artificial-intelligence-and-machine-learning>
- Basel Committee on Banking Supervision. (2021). Digitalisation of finance. Bank for International Settlements. Retrieved from <https://www.bis.org/bcbs/publ/d575.htm>
- Basel Committee on Banking Supervision. (2022, March 16). Newsletter on artificial intelligence and machine learning. Bank for International Settlements. https://www.bis.org/publ/bcbs_nl27.htm
- Consumer Financial Protection Bureau. (2022, May 26). Consumer Financial Protection Circular 2022-03: Adverse action notification requirements in connection with credit decisions based on complex algorithms. <https://www.consumerfinance.gov/compliance/circulars/circular-2022-03-adverse-action-notification-requirements-in-connection-with-credit-decisions-based-on-complex-algorithms/>
- Crisanto, J. C., Leuterio, C. B., Prenio, J., & Yong, J. (2024, December 12). Regulating AI in the financial sector: Recent developments and main challenges (FSI Insights on policy implementation No. 63). Bank for International Settlements. <https://www.bis.org/fsi/publ/insights63.htm>
- EU. (2024). EuroProposal for a Regulation of the European Parliament and of the Council Laying Down Harmonised Rules on Artificial Intelligence (Artificial Intelligence Act) and Amending Certain Union Legislative Acts. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A52021PC0206>
- Financial Conduct Authority. (2024, April). AI update: Our approach to artificial intelligence. <https://www.fca.org.uk/publication/corporate/ai-update.pdf>

- Financial Services Commission. (2021, July 8). FSC introduces guideline on the use of artificial intelligence in financial services. <https://www.fsc.go.kr/eng/pr010101/76209Digital>
- FSOC. (2023). Financial Stability Oversight Council Releases 2023 Annual Report. U.S. Department of the Treasury. <https://home.treasury.gov/news/press-releases/jy1991>
- Interfax. (2024, August 14). Uzbekistan set to draft AI regulations. <https://interfax.com/newsroom/top-stories/105117/>
- International Organization of Securities Commissions. (2021). The use of artificial intelligence and machine learning by market intermediaries and asset managers (FR06/2021). <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD684.pdf>
- Kerr-Shaw, N., & Adams, W. (2024, May 2). UK regulators publish approaches to AI regulation in financial services. Skadden, Arps, Slate, Meagher & Flom LLP. <https://www.skadden.com/insights/publications/2024/05/uk-regulators-publish-approaches-to-ai>
- Ministry of Internal Affairs and Communications. (2019). AI R&D guidelines for international discussions. https://www.soumu.go.jp/main_content/000584566.pdf
- Monetary Authority of Singapore. (2019, November 13). MAS partners financial industry to create framework for responsible use of AI. <https://www.mas.gov.sg/news/media-releases/2019/mas-partners-financial-industry-to-create-framework-for-responsible-use-of-ai>
- Organisation for Economic Co-operation and Development. (2024, September 5). Regulatory approaches to Artificial Intelligence in finance (OECD Artificial Intelligence Papers, No. 24). OECD Publishing. <https://doi.org/10.1787/f1498c02-en>
- Personal Information Protection Commission. (2022). Act on the Protection of Personal Information (as amended in 2022). https://www.ppc.go.jp/files/pdf/APPI_english.pdf
- Pokidaev, D. (2025, March 7). Kazakhstan introduces AI regulation bill to ensure human oversight. The Times of Central Asia. <https://timesca.com/kazakhstan-introduces-ai-regulation-bill-to-ensure-human-oversight/>
- Randall, S. (2024, November 15). Financial services' adoption of AI comes with significant risks, warns FSB. Wealth Professional. <https://www.wealthprofessional.ca/news/industry-news/financial-services-adoption-of-ai-comes-with-significant-risks-warns-fsb/387578>
- The Global Treasurer. (2024, December 12). BIS highlights AI risks for finance. <https://www.theglobaltreasurer.com/2024/12/12/bis-highlights-ai-risks-for-finance/>
- UK Government. (2016). Data Protection Act 2018, incorporating the UK General Data Protection Regulation, Article 22. <https://www.legislation.gov.uk/eur/2016/679/article/22>
- U.S. Department of the Treasury. (2024, December). Artificial intelligence in financial services: Uses, opportunities, and risks. <https://home.treasury.gov/system/files/136/Artificial-Intelligence-in-Financial-Services.pdf>
- World Bank. (2022, December 12). Global trends in AI governance (Report No. P178616). <https://documents1.worldbank.org/curated/en/099120224205026271/pdf/P1786161ad76ca0ae1ba3b1558ca4ff88ba.pdf>



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №57

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ЦАХИМААР ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХ НЬ ЯМАР ЭРСДЭЛТЭЙ ВЭ?



Цахим орчноос үнэт эдлэл худалдан авснаар танд үүсэж болзошгүй **ЭРСДЭЛҮҮД**:



Хуурамч бүтээгдэхүүн байх – Үнэт металл бус энгийн металлаар хийгдсэн, сорьцын баталгаагүй, дуураймал бүтээгдэхүүн байх магадлалтай!



Баталгаагүй борлуулагч байх – Үнэт чулуу болон үнэт эдлэл худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй, хаяг байршил нь тодорхойгүй хувь хүнээс худалдан авах нь эрсдэлтэй!



Буцаалт болон хохирлыг нөхөн олгохгүй байх – Таны худалдан авсан бараа шаардлага хангахгүй тохиолдолд барааг буцаахгүй, хохирлыг нөхөн төлөхгүй байх магадлалтай!



Зохиомлоор яаралтай нөхцөл байдал үүсгэх – "Хямдралтай", "бараг дуусаж байна" гэх мэт гарчигтай зар нь таныг эрсдэлтэй худалдан авалт хийхэд хүргэж болзошгүй!




Зээлээр эсхүл урьдчилгаа авах нэрээр залилан хийх – Урьдчилгаа 50% төлөөд захиалга хийх нөхцөлтэй цахим залилан байх эрсдэлтэй!

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС:

 **Зөвшөөрөлтэй хувь хүн, байгууллагаар үйлчлүүлэх** – Баталгаатай, хаяг байршил нь тодорхой, тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдээс авах.

 **Сорьц, гарал үүсэл, баталгааны бичгийг шалгах** – Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан сорьцын баталгааны тэмдэгтэй, эрдэнийн чулууны гэрчилгээтэй үнэт эдлэл худалдан авах.

Мөнгө	Алт Цагаан алт	Платина	Палладий
 925 999 925 875 835 800	 585 999 960 916 750 585 375 333	 950 950 900 850	 850 850 800





 **Буцаалт, баталгааны нөхцөлийг нягтлах** – Үйлчилгээний нөхцөл, буцаалт, хөнгөлөлтийн нөхцөлийг сайтар уншиж, танилцах.


 **Үнийн бодит байдлыг харьцуулах** – Зах зээлийн дундаж үнэтэй харьцуулан, хэт хямд үнэтэй чанаргүй бүтээгдэхүүн худалдан авахаас сэргийлэх.

 **Мэдээлэл авах** – Тусгай зөвшөөрөлтэй холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, сорьцын талаарх мэдээллийг Стандарт хэмжилзүйн газраас авна уу.


Санхүүгийн зохицуулах хороо, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар


 Утас: 51-262607, 51-262604

 Цахим хуудас www.frc.mn


 Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, 15160


Стандарт хэмжилзүйн газар, Сорьцын хяналтын газар

 Утас: 77005757, 75778430

 Цахим хуудас www.masm.gov.mn

Стандарт хэмжилзүйн газрын 1-р байр,

 Энхтайваны өргөн чөлөө 46А, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг дараах  QR кодыг уншуулан шалгах боломжтой.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН САНГИЙН ХҮҮГИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭЖ АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ӨГӨӨЖ, АМ.ДОЛЛАР ӨСӨВ.



12 дугаар сарын 8 – Энэ долоо хоногт болох Холбооны нөөцийн сан (ХНС)-ийн хурлыг хөрөнгө оруулагчид хүлээж буйтай холбоотойгоор Даваа гарагт АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж болон ам.долларын ханш бага зэрэг өсөв. Зах зээлийн оролцогчид бодлогын хүүг бууруулна гэж өргөнөөр таамаглаж байгаа ч голлох хөрөнгийн индексүүд уналттай байлаа.

Фьючерсийн зах зээлийн тооцоололд үндэслэсэн CME Group-ийн FedWatch-ын үзүүлэлтээр Холбооны нөөцийн сан бодлогын хүүг 25 суурь нэгжээр бууруулах магадлал 87.4 хувь байна. Гэвч зарим шинжээчид ХНС-ийн Бодлогын хороо дотоод санал зөрөлдөөн их байж болзошгүйг анхааруулжээ.

Японы зүүн хойд бүсэд болсон 7.6 магнитудын газар хөдлөлтийн дараа ам.доллар иений эсрэг чангарч, iShares MSCI Japan Сангийн хөрөнгө 0.6 хувиар буурсан байна. Шинжээчдийн үзэж буйгаар, уг байгалийн гамшиг Японы Төв банкны (BOJ) ирэх долоо хоногт хүлээгдэж буй бодлогын хүүгийн өсөлтийг хойшлуулах эрсдэлийг нэмэгдүүлжээ.

АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж 4.17 хувь болж, гурав дахь өдрөө дараалан өсөв. Харин хөрөнгийн зах зээлд Dow Jones, S&P 500, Nasdaq индексүүд тус тус буурч хаагдлаа.

Дэлхийн зах зээлийн MSCI индекс болон Европын STOXX 600 мөн буурсан байна.

Эрчим хүчний зах зээлд АНУ-ын түүхий нефтийн үнэ 1.20 ам.доллараар буурч 58.88 ам.доллар, Brent нефть 62.49 ам.долларт хүрч хаагдлаа.

Эх сурвалж: www.reuters.com

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН САН БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛСНЫ ДАРАА АЛТ ӨСӨЖ, МӨНГӨ ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ.



12 дугаар сарын 10 – Холбооны нөөцийн сан (ХНС) бодлогын хүүг бууруулсны дараа Лхагва гарагт алтны үнэ буцаад өссөн ч ирэх жилийн мөнгөний бодлогын төлөв тодорхой бус хэвээр байгааг зах зээлүүд харууллаа. Харин мөнгө түүхэн дээд түвшинд хүрэв.

Спот алт Нью-Йоркийн цагаар 15:17 цагийн байдлаар унц нь 4,236.57 ам.доллар болж, өмнөх өдрөөс 0.7 хувиар өссөн байна. Харин АНУ-д хоёрдугаар сард нийлүүлэх алтны фьючерс 0.3 хувиар буурч, 4,224.70 ам.долларт хаагдлаа.

ХНС бодлогын хүүг санал зөрөлдсөн шийдвэрээр дахин бууруулсан боловч хөдөлмөрийн зах зээл болон инфляцын хандлагын талаар илүү тодорхой дохио гарах хүртэл цаашид хүүгийн бууралтыг түр зогсоох магадлалтайг илэрхийлэв.

Бодлогын хүү буурах нь хүүгийн өгөөжгүй хөрөнгө болох алтанд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлдэг.

АНУ-ын Төв банкны бодлого тодорхойлогчдын олонх нь ирэх онд богино хугацааны хүүг бууруулах шаардлагатай гэж үзэж байгаа ч хэдэн удаа, ямар хэмжээгээр бууруулах талаар байр суурь ихээхэн зөрүүтэй байна. Зарим гишүүд хүүг огт бууруулах шаардлагагүй гэж үзэж байгаа бол гурван гишүүн хүүг нэмэгдүүлэх санал гаргажээ.

Үүний зэрэгцээ ХНС-ийн дарга Жером Пауэлл одоогийн мөнгөний бодлого нь эдийн засагт үүсэж болзошгүй нөхцөл байдалд уян хатан хариу үзүүлэхэд хангалттай сайн байр суурьтай байна гэж мэдэгдсэн ч ойрын хугацаанд бодлогын хүүг дахин бууруулах эсэх талаар тодорхой чиглэл өгөхөөс татгалзав.

Спот зах зээл дэх мөнгөний үнэ 61.85 ам.долларт хүрч, түүхэн дээд түвшнийг тогтоов. Мөнгөний үнэ энэ онд 113 хувиар өссөн нь үйлдвэрлэлийн эрэлт нэмэгдсэн, нөөц хомсодсон, мөн АНУ мөнгийг “чухал ашигт малтмал” хэмээн ангилсантай холбоотойгоор дэмжигдэж байна.

“Манай үнэлгээгээр, алтны үнийн ухралтын дараа илүү өндөр өгөөжийн боломж хайсан спекулятив хөрөнгийн урсгал мөнгө рүү чиглэснээр түүний гүйцэтгэл илүү давуу болж байна,” хэмээн SP Angel компанийн шинжээчид тэмдэглэв.

Харин бусад үнэт металлуудын хувьд платинум 2.4 хувиар буурч 1,654.55 ам.доллар, палладий 2 хувиар буурч 1,475.94 ам.долларт тус тус хүрлээ.

Эх сурвалж: www.reuters.com

BANK of America БАЯЛГИЙН УДИРДЛАГЫН ХАРИЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН КРИПТОД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БОЛОМЖИЙГ ӨРГӨТГӨВ.



2025 оны 12 сарын 4.

2026 оны 1 сарын 05-ны өдрөөс Bank of America Private Bank, Merrill, Merrill Edge-ийн зөвлөхүүд ямар нэгэн хөрөнгийн доод босго тавилгүйгээр харилцагчдад крипто биржээр арилжаалагддаг бүтээгдэхүүнүүд санал болгох боломжтой боллоо. Өмнө нь 2024 оны эхнээс зөвхөн хөрөнгийн тодорхой босго хангасан харилцагчид биткойны ETF-ээр дамжуулан крипто руу хөрөнгө оруулж байсан бөгөөд зөвлөхүүд голчлон харилцагчийн захиалгыг гүйцэтгэх үүрэгтэй байв. Шинэ шийдвэрээр зөвлөхүүд крипто хөрөнгийн талаар стратегийн зөвлөгөө өгдөг бодит зөвлөх болж хувирч байна.

АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп дижитал хөрөнгийн зах зээлд зохицуулалтын тодорхой хөнгөлөлт, хөнгөвчлөл хийхийг эрчимтэй дэмжиж буй энэ үед институтийн хөрөнгө оруулагчдын дунд крипто хөрөнгийг улам өргөн хэмжээнд ашиглах хандлага эрчимжиж байна. Хөрөнгө оруулагчид шууд койн эзэмшихээс илүүтэй, хөрвөх чадвар өндөр, хадгалалт, аюулгүй байдлын эрсдэл харьцангуй бага, зохицуулалтын комплайнс нь ойлгомжтой ETF болон ETP – ээр дамжуулан криптод хөрөнгө байршуулахыг илүүд үзэж байна.

Merrill болон Bank of America Private Bank-ийн Хөрөнгө оруулалтын ерөнхий захирал Крис Хайзи “Шинэ чиг хандлага, инновацыг идэвхтэй сонирхдог, хэлбэлзэл өндөр зах зээлд эрсдэл хүлээх чадвартай хөрөнгө оруулагчдын хувьд крипто хөрөнгөнд 1–4 хувийн хуваарилалт хийх нь боломжит, зохистой түвшин” хэмээн мэдэгджээ.

Эх сурвалж: www.reuters.com


FINANCE
WORLD

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

S&P 500 / ^GSPC/

6,774.76 +53.33 (+0.79%)




Nikkei 225 / ^N225/

49,606.11 +604.61 (+1.23%)




FTSE 100 / ^FTSE/

9,837.77 +63.45 (+0.65%)



NASDAQ Composite (^IXIC)

23,006.36 +313.04 (+1.38%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ӨС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

